# ХӨРӨНГӨ БИТҮҮМЖЛЭХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ТАЛУУДЫН ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

Б.Замбага
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш,
ахмад

***Товч агуулга:*** Энэхүү өгүүллээршүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгө битүүмжлэх, хөрөнгөд хамгаалалт тогтоох ажиллагааг шуурхай зохион байгуулах нь шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх нөхцөл бүрдэх буюу төлбөр авагчийн эрх хангагдах, нөгөө талаасаа төлбөр төлөгчийн хөрөнгө үнэгүйдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бусдад учруулсан хохирол, төлбөртөө санал болгох эрхийг хангах арга, хэрэгсэл болохыг тодорхойлохыг зорилоо.

***Түлхүүр үгс:*** Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах, төлбөрт гаргуулсан хөрөнгө, хөрөнгө хамгаалах, нэгтгэн гүйцэтгэх, барьцаа хөрөнгийн дараалал, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, үнийн санал, төлбөрт тооцон авах эрх, төлбөр төлөгчийн эрх.

“Та байгаа газраа, байгаа
зүйлээрээ чадах зүйлээ хий...”
ТеодорРузьвелт.

## Оршил

Бид ихэнх төлөв аргагүй тулгамдаж мухардсан үедээ л хуульд хандаж тусламж эрдэг. Гэтэл бидний өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааг анхааралтай ажиглавал тэр бүхэнд эрх зүй үйлчилж байгааг харах болно[159] гэж академич Ж.Амарсанаа хэлсэн байдаг.

Хуульд хандаж хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдийн аливаа эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэх эрхийг “Шүүх[160]” эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлж, түүний биелэлтийг хангах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үндсэн чиг үүргийг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

[159]Амарсанаа, Ж. Эрх зүй-Нийгмийн харилцааг тохируулагч. -Уб., 1988. 3дахь тал.
[160]Монгол Улсын Шүүхийн тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №6. 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэг “."шүүх" гэж Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг” хэлнэ.

байгууллага[161] ” шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгэдэг. Төрийн байгууллагын энэхүү үйл ажиллагааны зорилго нь хүний эрхийг сэргээн эдлүүлэх, хөндөгдөх явдлаас урьдчилан сэргийлэх байдаг. Нийгмийн хөгжлийн үйл явц, эдийн засгийн өөрчлөлт, техник, технологийн дэвшил, ажил, үйлчилгээний онцлогоос шалтгаалан эд хөрөнгийн шинжтэй, олон хүнийг хамруулсан маргаан шүүхээр хянан шийдвэрлэгдэх нь ихсэж байгааг шүүхийн шийдвэрийн цахим сан[162], гэмт хэргийн тоон судалгаанаас харж болохоор байна. Үүнтэй уялдан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ачаалал ч тэр хэрээрээ нэмэгдэж, хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт, эрх зүйн гаргалгаа шаардаж байна. Тухайлбал: Нийтийн мэдээллийн сүлжээнд тарсан, олон хүнийг хамарсан, төлбөрийн үнийн дүн өндөртэй зарим жишээг дурдаж болох юм. “Жи тайм сүлжээ[163]”-ны хэрэг болох Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 2020/ШЦТ/687 дугаар шийтгэх тогтоолоор Э.О-оос 11.880.540.432,0 төгрөг, нэр бүхий 906 иргэний хариуцагчаас 6.881.661.229,0 төгрөгийн хохирол, төлбөрийг гаргуулж 11350 хохирогчид олгохоор, “Нарны хүү, сарны охин ХХК[164]”-нд холбогдох Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 2021/ШЦТ/1032 дугаар шийтгэх тогтоолоор Д.Г, Д.О, Д.Б нараас 7.265.839.273,0 төгрөгийг гаргуулж 389 иргэнд олгохоор шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрүүд болон нэг шүүхийн шийдвэрээр биш ч олон шүүхийн шийдвэрээр нэг хүн, хуулийн этгээдэдээс олон хүн, хуулийн этгээдэд хохирол учруулсан олон арван шүүхийн шийдвэрүүдийг дурдаж болно.

Эдгээртэй зэрэгцэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээдээс шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд саад учруулах нь сүүлийн жилүүдэд

[161]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017.№24. 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлнэ’’ гэж заасан.

[162]Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан Залилах гэмт хэргийн тоон үзүүлэлтийг 17.3 дугаар зүйлийн 2.2, 3.1, 3.2, 3.3 дахь хэсэгт заасанаар шүүж үзэхэд 2022 оны гуравдугаар улирлын байдлаар /2022.09.03/ 399 гэмт хэрэг, 2021 онд 781, 2020 онд 599, 2019 онд 643, 2018 онд 427 гэмт хэрэг тус тус хянан шийдвэрлэгдсэн байна. Үүнээс олон хүнийг хамруулан олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн гэмт хэрэг нь 2018 онд 1, 2019 онд 1, 2020 онд 4, 2021 онд 2, 2022 оны гуравдугаар улирлын байдлаар шийдвэрлэгдээгүй байна.

[163]Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 2020/ШЦТ/687 дугаар шийтгэх тогтоолоор Э.О-оос 11.880.540.432,0 төгрөг, нэр бүхий 906 иргэний хариуцагчаас 6.881.661.229,0 төгрөгийн хохирол, төлбөрийг гаргуулж 11350 хохирогчид олгохоор шийдвэрлэсэн. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn).

[164]Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 2021/ШЦТ/1032 дугаар шийтгэх тогтоолоор Д.Г, Д.О, Д.Б нараас 7.265.839.273,0 төгрөгийг гаргуулж 389 иргэнд олгохоор шийдвэрлэгдсэн. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)

харьцангуй өссөн үзүүлэлттэй байгаа нь статистик мэдээллээс харагддаг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд санаатайгаар саад учруулсан, хөдлөх болон үл хөрөнгөө бусдад шилжүүлсэн, нуун дарагдуулсан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээсэн 15[165], зөрчлийн тухай хуульд[166] зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан 232 [167] хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээжээ.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгөө нуун далдлаагүй, бусдад шилжүүлээгүй боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах, хугацаа хожих зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаа хууль бус, талуудын эрхийг зөрчиж явагдсан гэж шүүхэд хандсан тохиолдол 2016 оноос 2022 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар гэхэд 1583[168] тохиолдол шийдвэрлэгдсэн байна. Эдгээр гомдол нь бүгд үндэслэлгүй биш ч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хугацаа хожих, шийдвэрийн биелэлтийг хангахаас зайлсхийх нэг арга болсныг дурдах нь зүйтэй. Улсын хэмжээнд Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд байгаа 37226 гүйцэтгэх баримт бичгийн 2589480860,5 төгрөгийн төлбөрийг биелүүлбэл зохихоос 14250 гүйцэтгэх баримт бичгийн 293455576,8 төгрөгийн төлбөрийг биелүүлж, гүйцэтгэх баримт бичгийн биелэлт 38,3 хувийн биелэлттэй ажиллаж байна.

[165] Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн үндэслэлээр сүүлийн 20 жилийн хугацаанд нийт 12 хүн эрүүгийн хариуцлага хүлээжээ. Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. №5. 258 дугаар зүйлийн 258.1, 258.2, 258.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээсэн 3, Эрүүгийн хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. №21. 21.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээсэн 12 этгээд байна.

[166]Зөрчлийн тухай хууль.//Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24. 15.27 дугаар зүйлд заасан үндэслэлээр

[167] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны Мэдээлэл, лавлагаа дүн шинжилгээний хэлтсийн 2021, 2022 оны Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн судалгаа. 2021 онд 122 зөрчил шалган шийдвэрлэснээс 80 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 20,0 сая төгрөгийн торгох шийтгэл, 6 зөрчлийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэж 5,0 сая төгрөг, хүүхдийн тэтгэлгийн 3 төлбөр төлөгчид 0,3 сая төгрөг, 30 төлөгчид 7-30 хоногийн баривчлах, албадан сургалтад хамруулах, 2022 оны эхний 8 сарын байдлаар 110 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулснаас 75 зөрчлийг хялбаршуулан шийдвэрлэж 18,2 сая төгрөгийн торгох шийтгэл, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар 1 холбогдогчийг 2,5 сая төгрөгөөр, хүүхдийн тэтгэлгийн 14 төлөгчид 1,4 сая төгрөгийн торгох, 19 тэтгэлэг төлөгчид 7-30 хоног баривчлах болон албадан сургалтад хамруулах шийтгэл ногдуулсан ажилласан байна.

[168]Шүүхийн шийдвэрийн цахим сангийн бүртгэлээс шүүж гаргав.

Зураг.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүүхэд хандсан маргааны төрөл, тоон үзүүлэлт /Төрлөөр/




Зураг.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүүхэд хандсан /Оноор 2016-2022/




Иймд нийгэм, эдийн засаг, техник технологийн хөгжилтэй уялдан шүүхээс гарсан шийдвэрийг бүрэн дүүрэн бодитой биелүүлэх, олон хохирогчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгө битүүмжлэх, хамгаалах үйл ажиллагааг цаг алдалгүй зохион байгуулах нь тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын эрхийг хөндөхгүй байх эрх зүйн хамгаалалт, зохицуулалтыг бүрдүүлэх, талуудын эрх хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага байгааг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж буй нийтлэг хугацаа, хууль, эрх зүйн зохицуулалт, практик үйл ажиллагааны явцад учирч байгаа зарим жишээнд тулгуурлан судлан үзлээ.

## Хөрөнгө битүүмжлэх ажиллагааны онцлог, дарааллын ач холбогдол

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийн хөрөнгийг төлбөрт шилжүүлэх, хөрөнгө бусдад шилжиж үрэгдэхээс хамгаалах, худалдан борлуулах, “хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураах тухай шүүхийн шийдвэрийг [169]” гүйцэтгэх зорилгоор тухайн хөрөнгийн захиран зарцуулах, түүнчлэн эзэмших, ашиглах эрхийг хязгаарлах ажиллагааг [170] бид хөрөнгө битүүмжлэх ажиллагаа гэж нэрлэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны онцлог, төлбөр төлөгч нь хүн, хуулийн этгээд байхаас хамааран төлбөр төлөгчийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаанд тодорхой дараалал тогтоож өгсөн байдаг. Төлбөр төлөгч иргэн[171] (хүн)-ээс төлбөр гаргуулахдаа эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаас, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, бусад хөрөнгөөс төлбөрийн шаардлагыг хангуулахаар дараалал тогтоосон.

Төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол[172] мөнгөн хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд шууд хэрэглэгдэхгүй бусад материал, үнэт зүйл, бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөрөнгийн эрх, бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй үл хөдлөх хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамаарал бүхий хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бараа, материал, бусад түүхий эд, техник, тоног төхөөрөмж, үнэт цааснаас төлбөр гаргуулахаар тогтоосон дарааллын дагуу шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тэгвэл хөрөнгө битүүмжлэх, барьцаалах шийдвэрийг баталгаажуулах ажиллагаа нь дээрх дарааллыг үл харгалзан, төлбөр төлөгчийн хөрөнгөө захиран зарцуулах эрхэд хязгаарлалт тогтоох буюу хөрөнгө битүүмжлэх буюу хамгаалах ажиллагааг зохион байгуулж болдгоороо онцлог. Учир нь хөрөнгө битүүмжлэх шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ нь мөнгөн хөрөнгөөс бусад хөрөнгийг хураах, худалдан борлуулах ажиллагааны урьдчилсан нөхцөл, хөрөнгийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлж байгаа тул дараалал харгалзахгүйгээр гүйцэтгэдэг. Энэ нь төлбөр төлөгч хөрөнгөө бусдад шилжүүлэх, нуун дарагдуулах, үрэгдүүлэх үндэслэлийг бүрдүүлэхээс урьдчилан сэргийлж, шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх нөхцөлийг бүрдүүлэх албадлагын арга, хэрэгслийн нэг байдаг.Ийнхүү хөрөнгө битүүмжлэхдээ хуульд заасан агуулга, хэлбэрийн шаардлага хангасан, тогтоолыг үйлдэж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчдод хөрөнгийн эрхэд тогтоосон хязгаарлалт, гүйцэтгэх

[169]Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамжийг биелэх ажиллагааг ойлгоно. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. №8. 69 дүгээр зүйл.

[170]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24. 49 дүгээр зүйл.

[171]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24. 86 дугаар зүйл.

[172]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24. 94 дүгээр зүйл.

баримт бичгийн шаардлагыг биелүүлэх талаар төлбөр төлөгчид олгосон хугацаа, тогтоосон хугацаанд шийдвэрийн биелэлтийг хангаагүйгээс үүсэх үр дагавар, хүлээлгэх хариуцлага, хөрөнгийн хадгалалтыг хариуцах этгээд, түүнд хүлээлгэх үүрэг, хөрөнгийн битүүмжлэл цуцлагдах үндэслэл зэргийг танилцуулж, шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэлээр баталгаажуулж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн байх шаардлагатай.

Битүүмжилсэн, барьцалсан шийдвэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх гэдэг нь "битүүмжилсэн, барьцаалсан хөрөнгө" нь бүртгэлийн эрхээр баталгааждаг[173] үл хөдлөх хөрөнгө, төлбөрт гаргуулж болохгүй хөдлөх эд хөрөнгө болон бусдын өмчлөлд шилжүүлж үл болох эрхээс бусад барьцааны зүйлээр тодорхойлогдсон хөрөнгийг битүүмжилсэн тогтоолыг Улсын бүртгэлийн байгууллагад ажлын гурван өдрийн дотор, хөдлөх болон эдийн бус хөрөнгөтэй холбоотой, барьцааны зүйлээр тодорхойлогдсон эрхийг битүүмжилсэн бол хөдлөх хөрөнгийн барьцаагаар бүртгүүлж, талуудын эрхийг хамгаалах ажиллагааг явуулах хэрэгтэй.Барьцааны зүйлээр тодорхойлогдсон хөдлөх болон эдийн бус хөрөнгө гэдэг нь "иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл[174] болдог.

Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, барьцааны зүйлээр тодорхойлогдсон хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлээ тэргүүн ээлжинд хангуулах, хэд хэдэн барьцаалагчийн эрхийн дарааллыг барьцаа баталгаажуулсан цаг хугацааны дарааллаар тодорхойлж, хэрэгжилтийг хангадаг тул шийдвэр гүйцэтгэгч битүүмжлэх, барьцаалах ажиллагааг хэрэгжүүлсэн даруйд үл хөдлөх хөрөнгө битүүмжилсэн тогтоолыг Улсын бүртгэлийн байгууллагад ажлын гурван өдрийн дотор, хөдлөх болон эдийн бус хөрөнгөтэй холбоотой эрхийг битүүмжилсэн бол хөдлөх хөрөнгийн барьцаагаар бүртгүүлж, тухайн эд хөрөнгөөс салж үл болох эрхийн хязгаарлалтыг тогтоох нь төлбөр авагч, төлбөр төлөгчийн хөрөнгөөс шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах салж үл болох эрхийг үүсдэг.

Эрхийн бүртгэлийн байгууллагад хүргүүлэх тогтоолдоо өмчлөх эрхийн гэрчилгээнд хамаарах хөрөнгийг бусдад салгаж бүртгэх байх, эд хөрөнгийн улсын бүртгэл хөдлөхгүй байх, шинээр өмчлөх эрхийн гэрчилгээ олгохгүй байхыг мэдэгдэж, бүртгэлд тэмдэглэгээ хийлгэж баталгаажуулна [175] .Энэ нь Шүүхийн

[173]Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018. №29. 5 дугаар зүйлийн 5.2.Эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.2 (бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийн), 8.1.3 (сервитутын), 8.1.4(ипотек /барьцаа/-ийн), 8.1.5(узуфруктын), 8.1.6(түрээсийн), 8.1.7(усан замын тээврийн хэрэгсэл, агаарын хөлгийн санхүүгийн түрээс /лизинг/-ийн гэрээний эрхийн), 8.1.8(батлан даалтын), 8.1.9(газар эзэмших, ашиглах эрхийн)-д заасан эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

[174] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015. №28. 7 дугаар зүйл.

[175]Өнөрцэцэг, Ч. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. -Уб., 2022. 88 дахь тал.

шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах ажиллагааны явцад дараах эрхийг олгодог:

1. Төлбөр төлөгчийн хөрөнгийг хураан авч үнэлгээ тогтоолгох ажиллагаанд үнэлгээний санал гаргах;

2. Дуудлага худалдаанд өөрийн санал гаргасан, харилцан тохиролцсон эсхүл шинжээчийн үнэлгээг хүлээн зөвшөөрсөн үнийн зохих хувиар оролцох[176];

3. Дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй эд хөрөнгийг Улсын бүртгэлийн байгууллагад хөрөнгийн бүртгэл, баталгаажуулалт хийгдсэн дараалал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гүйцэтгэх баримт бичиг бүртгэгдсэн дарааллаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах эрх үүсдэг.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад нэг төлбөр төлөгчтэй хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгээр, хэд хэдэн төлбөр авагчид холбогдох баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 112 дугаар зүйлд заасан “Хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг хангах дараалал”-ын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулж, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлдэг боловч практик үйл ажиллагааны явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад дараа нь ирүүлсэн төлбөр авагчийн төлбөрийн үнийн дүн, шүүхийн шийдвэрийн мэдээллийг тэр бүр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхгүйгээр өмнө явагдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны баримтыг дараа ирсэн баримт бичигт хуулбарлан хийж, бүртгэлийн байгууллагад хуульд зааснаар үүсэх барьцааны эрхийн баталгаа хийлгээгүйгээс төлбөр авагчийн дараах эрх зөрчигдөх тохиолдолд гарч байгаа нь шүүхийн шийдвэрийн цахим сан дахь “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүйд тооцсон” шийдвэр, гомдол хянан шийдвэрлэсэн материал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зохицуулалтуудаас харагдаж байна.

1. Өмнө шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, төлбөр төлөгчийн төлбөрийн шаардлага хангахуйц хөрөнгийг хураан авч үнэлгээ тогтоолгох ажиллагаанд үнийн санал өгөх эрхгүй;

2. Дуудлага худалдаанд Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.3 дахь хэсэгт зааснаар оролцох эрх;

3. Худалдан борлогдоогүй хөрөнгийг өмнөх төлбөр авагч төлбөртөө тооцон аваагүй нөхцөлд санал гаргасан, харилцан тохиролцсон үнэлгээгээрээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсэгт зааснаар хүлээн авах эрх хязгаарлагдах боломжтой байна.Нөгөө талаар төлбөр төлөгч этгээдийн хувьд барьцааны эрх тогтоолгоогүйгээс дээрх эрх дараах байдлаар хязгаарлагдаж байна.

1. Өөрийн өмчлөлийн хөрөнгөөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бүхий л хохирол, төлбөрөө барагдуулах;

2. Өөрийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бусад төлбөр авагч нараар болон үнэлгээчнээр үнэлүүлэх эрх хөндөгдөх боломжтой байна.

[176]Иргэний хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. №7. 175 дугаар зүйлийн 175.3 дахь хэсэг.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад битүүмжилсэн, барьцаалсан төлбөрийн шаардлага хангахуйц хөрөнгөөс хэд хэдэн төлбөр авагчийн шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөрийн шаардлагыг хангуулахын тулд хуульд тусгайлан зохицуулсан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, хэвшүүлэх шаардлага байна. Талуудын эрхийг хамгаалсан, дэмжсэн, хууль, эрх зүйн зохицуулалтыгтунхгийн шинжтэй зарчим гэж ойлгохгүйгээр хэрэглэх, батлагдсан хуулийн үзэл баримтлалд нь нийцсэн тэр агуулга, зарчмаар бид ойлголтоо нэгтгэж, чиг хандлагаа зөв тогтооход хүчин чармайлт гаргаж ажиллах нь зайлшгүй тулгамдсан асуудал болоод байгаа нь дээр дурдсан онцлог бүхий шүүхийн шийдвэрүүд, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэр зэргээс харж болно.

Иргэд хэрэг маргаанаа аль болох чирэгдэлгүй, хугацаа алдахгүй, үнэн зөв шийдвэрлүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ханддаг. Гэтэл бидэнд хандаад бүр их чирэгддэг, цаг хугацаагаа алддаг[177], илүү төвөг үүсдэг байж болохгүй. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийн хөрөнгийг битүүмжлэхдээ барьцаа тогтоогоогүйгээс үүссэн эрхийн зөрчилтэй гэж үзэж шүүхэд хандсаны улмаас болон бусад олон хүчин зүйлээс шалтгаалан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширч байгаа нь дараах судалгаагаар нотлогддог.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа дундаж хугацааг тодруулах зорилгоор улсын хэмжээний нийт 253 шийдвэр гүйцэтгэгчээс авсан санал асуулгын дүнг харахад нийт гүйцэтгэх баримт бичгийн 50 орчим хувь нь нэгээс хоёр жил, түүнээс дээш хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан байна. Тухайлбал:1-хоногоос 1 сарын хугацаанд биелэгдсэн гэж 0, 1 сараас 3 сарын хугацаанд биелэгдсэн гэж 17, 3 сараас 6 сарын хугацаанд биелэгдсэн гэж 31, 6 сараас 9 сарын хугацаанд биелэгдсэн гэж 42, 9 сараас 1 жилийн хугацаанд биелэгдсэн гэж 37, 1 жилээс 2 жилийн хугацаанд биелэгдсэн гэж 81,2 ба түүнээс дээш жил гэж 45-н шийдвэр гүйцэтгэгч үнэлсэн байдаг.




[177] Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа дундаж хугацааны талаарх нэгдсэн судалгаагаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа нийт баримт бичгийн 50 орчим хувь нь нэгээс хоёр жил, түүнээс хугацаанд биелэгдэж байгаа судалгаа гарсан.

## Дүгнэлт

Хуний эрх эрх чөлөөг хэр хангаж байна вэ гэдгээр нь тухайн улсын олон улсын түвшинд эзлэх байр суурь, нийгмийн хөгжлийн түвшин зэргийг тодорхойлох боломжтой юм. Тиймээс ч ардчилсан гэгдэж буй улс гүрнүүд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх явдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгож, түүнийг хангахын төлөө ихээхэн чармайлт гарган ажилладаг[178].

Шүүхийн шийдвэрээр хамгаалагдсан хүн, хуулийн этгээдийн эрхийг хангах, бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй төрийн албадлагын арга хэрэгсэл болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ төрлийн харилцааг зохицуулж буй хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангаж, хүлээсэн үүрэгтээ үнэнч /хариуцлагатай/, эрх зүйн хэм хэмжээ амьдралд хэрэгжих, эрх зүйн соёлыг төлөвшүүлэх бодит боломжийг бий болгож, үлгэрлэх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, шийдвэр гүйцэтгэгч та бидний үүрэг юм. “Хариуцлага” нь “үүрэг” гэсэн хэлбэр талын шинжийг агуулах боловч, түүний бодит мөн чанар нь “бусдыг хайрлах, бусдын эрхийг хүндэтгэх, хангахад" оршиж байдгийг цаг ямарт санаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөрөнгө битүүмжлэх, барьцаалах үйл ажиллагааг явуулахдаа хуульд заасан агуулга, хэлбэрийн шаардлагыг бүрэн баталгаажуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавих хяналтыгүе шаттайгаар сайжруулж, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байна гэж дүгнэлээ.

## Эх сурвалжийн жагсаалт


**Хууль:**

Монгол улсын шүүхийн тухай хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №6.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017.№24.

Эрүүгийн хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. №5.

Эрүүгийн хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. №21.

Зөрчлийн тухай хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

Иргэний хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. №7.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002. №8.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018. №295

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль. //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015. №28.

**Ном, сурах бичиг:**

Амарсанаа, ж. Эрх зүй-нийгмийн харилцааг тохируулагч. -уб., 1988.

Нармандах, б. Үндсэн хуулийн эрх зүй. -уб., 2011.

Өнөрцэцэг, ч. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт. -уб., 2022

**Цахим эх сурвалж:**

https://www.leqalinfo.mn/

Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn).


[178]Б.Нармандах., Үндсэн хуулийн эрх зүй., УБ., 2011., 123 дах тал